



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/92

Мандалговь

**“Монгол машин индустриал” ХХК-тай гэрээ  
байгуулах тухай**

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А/05 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн төвийн нийтийн тээврийн 12 хүний суудалтай 2 эко автобус нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Монгол машин индустриал” ХХК-тай 99,990,000 (ерэн есөн сая есөн зуун ерэн мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу “Аймгийн төвийн нийтийн тээврийн 12 хүний суудалтай 2 эко автобус нийлүүлэх” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Монгол машин индустриал” ХХК-ны гүйцэтгэх захирал (Д.Ариунболд)-д үүрэг болгосугай.

Гурав.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын захирагч (Р.Мөнхтогтох), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060398